

**Эрүүл мэндийн салбарын 2024-2028 оны стратеги
төлөвлөгөөний бүтэц, агуулга**

Бүлэг 1. Нийтлэг үндэслэл

Бүлэг 2. Мандатын шинжилгээ

Бүлэг 3. Алсын хараа

Бүлэг 4. Эрхэм зорилго

Бүлэг 5. Орчны шинжилгээ

Бүлэг 6. Стратегийн зорилго

Бүлэг 7. Стратегийн зорилго ба салбар нутаг дэвсгэрийн нэгж байгууллагын бүтцийн уялдаа зураглал

Бүлэг 8. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт суурь болон зорилтот түвшин стратеги төлөвлөгөөний матриц

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Аймгийн түүх

Завхан аймаг нь 1923 онд байгуулагдсан. Монгол Улсын баруун хэсэгт баруун талаараа Ховд, Увс, хойд талаараа Оросын холбооны Тува улс, зүүн талаараа Хөвсгөл, Архангай, урд талаараа Баянхонгор, Говь-Алтай аймгуудтай хиллэдэг. Нутаг дэвсгэр нь 82,4 мян.км.кв, хүн ам нь 75889 мянга, Улаанбаатар хотоос 1050 км зайдай оршдог.

Аймгийн төв Улиастай хот нь 1733 онд байгуулагдсан, 17000 мянган хүн амтай. Тус аймаг нь засаг захиргааны 24 нэгжид хуваагддаг бөгөөд хамгийн хол сум нь аймгийн төвөөс 327 км алслагдсан /Тэс сум/.

Хангайн нурууны салбар уулсууд нутаг дэвсгэрийн дийлэнхи хэсгийг эзэлдэг бөгөөд өндөр даваа гүвээ олонтой, зам тээвэр харьцангуй сул хөгжсөн. 200-гаад түргэн урсгалт гол горхи, 100 шахам том, жижиг нууртай, Отгонтэнгэр, Улаанхаалга, Баянзүрх, Зарт, Хожуулын рашан сувилал, Улаан эрэг, Баян-сүг зураг, буган чулуу, хүн чулуун хөшөө дурсгалууд, 18 дугаар зууны үеийн цэргийн цайз, худалдаа, наймааны хот, хүрээ, хийд дуган сүмийн туурь, газар тариалангийн ул мөр бүхий 100 шахам түүх дурсгалын өв хамгаалалтад байдаг.

Аймгийн Төв Улиастай хот нь Зүүн талдаа хангайн нурууны гол оргил Отгонтэнгэр /4031м/, түүний салбар Тарвагатай, /3227м/ Хуримт, Түдэвтэй, Гурван Халтар, Гялгар, Булнайн /2619 м/ нуруу, хойд хилийн дагуу Тагнын нурууны салбар уулстай уулархаг нутагтай бөгөөд баруун хэсэг нь гүвээ толгод, гол хөндий зонхилсон хээр тал нутагтай юм. Улсын хооронд Идэр, Завхан, Тэс, Богдын гол болон Хүнгийн голын өргөн хөндийтэй. Баруун, Баруун урд хэсэгт Монголын их элс, Бор хярын элсэн манханууд 100-200 км үргэлжилдэг. Төмрийн хүдэр, цагаан тугалга, алт, зэс, алмаз, молибдений хүдэр, үнэт чулуу, хайлуур жонш, фосфорид, хүдэр, химиин болон барилгын түүхий эдийн баялагтай юм. Ойдоо зэрлэг жимсний нөөц ихтэй. Цаг агаарын эрс тэс уур амьсгалтай, өвөлдөө 50 хэм хүртэл хүйтэрч, зундаа 35 хэм хүртэл халдаг.

1.2. Эрүүл мэндийн салбарын түүх

Завхан аймагт эрүүл мэндийн салбарын үндэс суурь нь 1929 онд Тухайн үеийн Оросын эрдэмтэн Белянскийн удирдлаган дор “Докторын газар” нэртэйгээр байгуулагджээ.

Завхан аймгийн Эрүүл мэндийн салбарт нийт... байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. Нэгдсэн эмнэлэг 2, ЗӨСТ, УАУТ, сумын эрүүл мэндийн төв 23 , өрхийн эмнэлэг 3, ор бүхий хувийн эмнэлэг, сувилал 7, үүдэн хувийн эмнэлэг 10, эм ханган нийлүүлэх байгууллага 6, хувийн эмийн сан 17, эмийн эргэлтийн сан 23

тус бүр ажиллаж байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй дээрхи 99 байгууллагуудад нийт 1085 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид ажиллаж байна.

Улсын хэмжээнд эрүүл мэндийн салбарын шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор эрүүл мэндийн салбарт хэд хэдэн бодлогын баримт бичиг, стратеги төлөвлөгөөг үндэсний болон салбарын түвшинд боловсруулан салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж ирсэн.

Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2007 оны 45 дугаар тогтоол "Монгол улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого"
- Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоол " Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод сууринсан Үндэсний хөгжлийн цогц бодлого";
- Эрүүл мэндийн сайдын 2013 оны 176 дугаар тушаал "Эрүүл мэндийн технологийн нэгдсэн бодлого"
- Монгол Улсын Их Хурлын 2014 оны 57 дугаар тоот тогтоол "Төрөөс эмийн талаар баримтлах бодлого"
- Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоол "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого".

Түүнчлэн сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд хүн амын эрүүл мэндэд тулгамдаж буй асуудлаар нийт 44 үндэсний хөтөлбөр. стратегийг Засгийн газрын тогтоол (14) болон Эрүүл мэндийн сайдын тушаалаар (19), яамд хоорондын хамтарсан тушаалаар (1) 4-10 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлж ирсэн.

Улсын хэмжээнд хүн амын дундаж наслалт 1992 онд 62.7 байсан бол 2021 онд 71.0 болж уртассан байна. Гэсэн хэдий ч салбарын хэмжээнд хэрэгжүүлэхээр батлагдсан бодлогын баримт бичиг нь тухайн үеийн улсын их хурал, Засгийн газар, хүний нөөцийн тогтвортгуй байдлаас шалтгаалан бодлогын залгамж холбоо алдагдах, санхүүжилт шийдвэрлэгдэхгүй байх зэргээс шалтгаалан тавьсан зорилгодоо хүрэхэд хүндрэл үүсч хэрэгжилт удааширч байсан. Манай аймгийн хувьд хүн амын дундаж наслалт 71 бөгөөд цаашид ЭРҮҮЛ ЗАВХАН 75+ хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

2020 онд батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн дагуу салбарт хэрэгжиж байсан дээрх олон төрлийн бодлогын баримт бичгийг хүчингүй болгон улсын хэмжээнд хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах ўе шат, цагалбарыг баталгаажуулсан.

Өнөөгийн байдлаар аймгийн эрүүл мэндийн салбарын хэмжээнд урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлогыг “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл. Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, 2025 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэгт тусган хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.


Дээрх хөгжлийн бодлогын баримт бичгийг амжилттай хэрэгжүүлэхэд салбарын хэмжээнд дунд хугацаанд хэрэгжүүлэх зорилт арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж жил бүрийн төсөв, байгууллагын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх шаардлагатай. Хөгжлийн бодлого. төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9-р зүйлийн 9.6-д Төрийн захиргааны төв байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүргийг заасан ба 9.6.5 дахь заалтад 'өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хөгжлийн бодлого. Төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго. зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх" гэж заасны дагуу аймгийн эрүүл мэндийн салбарын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж байна.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн Газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам болон Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 100 дугаар тушаалын төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу боловсрууллаа.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан "Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-ын дагуу салбарын чиг үүргийн мандатын шинжилгээг 2020 онд хийсэн. Уг шинжилгээгээр Монгол Улсын үндсэн хууль болон хүн амын эрүүл мэнд, эрүүл мэндийн тусlamж үйлчилгээтэй холбогдол бүхий хууль, засгийн газрын тогтоол шийдвэр, эрүүл мэндийн сайдын тушаал зэрэгт дүн шинжилгээ хийсэн байна.

Дүн шинжилгээ хийхдээ аймгийн эрүүл мэндийн салбарын чиг үүргийг дараахь байдлаар тодорхойлсон байна.



ГУРАВ. АЛСЫН ХАРАА

“Эрүүл мэндийн төлөө хамтдаа”

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, өвчинөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, нотолгоонд суурилсан оношлогоо, эмчилгээний шинэ техник, технологийг нэвтрүүлэх замаар тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан дундаж наслалтыг уртасгаж амьдралын чанарыг сайжруулахад оршино.

ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛ. /Эрүүл Мэндийн Газар/

- Эрдэм мэдлэгийг эрхэмлэсэн, Эрч хүчтэй, Эрх тэгш нээлттэй,
- Мэдлэг чадвартай, мэргэшсэн, ёс зүйтэй багаар ажиллахыг эрхэмлэдэг
- Гүйцэтгэл нь чанартай, үйлчилгээ нь тэгш хүртээмжтэй, үйл ажиллагаа нь ил тод хариуцлагатай байхыг эрхэмлэнэ.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Нэг ДОТООД ОРЧИН

Давуу тал	Сул тал
1. Бүтэц, зохион байгуулалт <p>Завхан аймгийн засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж бүрт эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлэх бүтэц зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоотой.</p> <p>Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бүтэц зохион байгуулалтыг баталгаажуулсан стандарттай</p> <p>Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг сумуудын хувьд бүсчлэн үзүүлэх Сум дундын эмнэлэгийн зохион байгуулалт стандарт батлагдсан эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг анхан болон лавлагаа шатлалын хэлбэрээр үзүүлэх тогтолцоо бий болсон.</p>	<p>Зарим сум аймгийн төвөөс хэт ойр зарим нь хэт алслагдсан байдалтай оршдог</p> <p>Одоо мөрдөгдөж байгаа Стандарт нь сумын эрүүл мэндийн төвд бүрэн хэрэгжих боломж хязгаарлагдмал АНЭ-т харьяа бусад аймгаас ирж үйлчлүүлж байгаа иргэдийн ачаалал их</p> <p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хүний нөөц, болон тоног төхөөрөмж, барилга байшингийн стандарт хангалтгүй.</p>
2. Хүний нөөц <p>Салбарын хүний нөөцийг бэлтгэх, сургах, чадавхижуулах нэгдсэн тогтолцоо бий болсон.</p> <p>Аймгийн хэмжээнд 10000 хүн амд ноогдох их эмчийн тоо... сувилагчийн тоо... баруун бүсийн аймгуудтай харьцуулахад байна.</p> <p>Мөн Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчинг баталгаажуулсан. Хүний нөөцийн программд бүртгэгдсэн хяналтын тогтолцоо бүрдсэн байна.</p> <p>Эрүүл мэндийн ажилтанг анхан шат болон лавлагаа шатлалын эмнэлэг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах зорилго бүхий нэг удаагийн тэтгэмжийн асуудлаар эрх зүйн орчныг хуулиар баталгаажуулсан.</p>	<p>Эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэн гаргаж байгаа анагаахын сургуулиудын чанар жигд бус Их эмчийн тоо хангалттай хэдий ч хөдөө орон нутагт их эмч дутагдалтай. Зарим төрлийн нарийн мэргэшлийн эмч аймгийн хэмжээнд дутагдалтай бөгөөд төрөлжсөн нарийн мэргэжлийн их эмчтэй харьцуулахад сувилагчийн тоо хангалтгүй мэргэшсэн болон мэргэжлийн зэрэгтэй сувилагч нар хангалттай бус байна. Ажил мэргэшлийн индекс хэт их төрөлжсөн. Орон нутагт ажиллах эмнэлгийн мэргэжилтэн дутагдалтай Орон нутагт ажиллах эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгаа (байр орон сууц) бүрэн хангагдаагүй Эмч нарыг нарийн мэргэшүүлэх үйл явц тусlamж үйчилгээний хэрэгцээ шаардлагатай уялдаа хангалтгүй.</p>
3. Салбарын санхүүжилт <p>Салбарын санхүүжилтийн шинэчлэл эхэлж гүйцэтгэлд суурилсан санхүүжилт нэвтэрч эхэлсэнээр Эрүүл мэндийн даатгалын сан ЭМЯ-ны харьянд шилжин ирсэнтэй холбогдуулан салбарын санхүүжилт нэмэгдсэн Анхан шатны</p>	<p>Гүйцэтгэлийн санхүүжилтийн талаар эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтан, хүний нөөцийн мэдлэг чадвар дутмаг, ойлголт хандлага жигд бус Эрүүл мэндийн салбарын санхүүжилт ДЭМБ-аас улс орнуудад зөвлөмж</p>

тусламж үйлчилгээний санхүүжилт 2015 оноос хойш 4 дахин нэмэгдэхийн зэрэгцээ зарим төрлийн тусламж үйлчилгээг ЭМД-ын сангаас гүйцэтгэлээр санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн Алслагдсан орон нутагт тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагад алслагдсан орон нутгийн индекс ашиглаж эхэлсэн нь ЭМД-с санхүүжиж байсан тусламж үйлчилгээний нэр төрөл, санхүүжилтийн хувь нэмэгдэж байгаа юм.	боловсон хэмжээнд хүрэхгүй байгаа Хувь хүний хармаанаас төлөх төлбөрийн хэмжээ ДЭМБ-ын зөвлөсөн хэмжээнээс өндөр хэвээр байна Салбарын санхүүгийн нөхцөл байдлыг илтгэх Үндэсний тооцооны чадавх бүрэн бүрэлдээгүй Эрүүл мэндийн эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн хүний нөөц хангалтгүй.
---	---

4. Салбарын засаглал, ил тод байдал

Аймгийн нэгдсэн эмнэлгийн хагас бие даасан байдал хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд АНЭ-н төлөөлөн удирдах зөвлөл байгуулгадж үйл ажиллагаагаа эхлүүлэх боломж бүрдсэн байна.

Салбарын хэмжээнд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороо байгуулгадан ажиллаж байна Салбарын хэмжээнд зарим үйл ажиллагааг төр. Хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийнбайгууллагаар гүйцэтгүүлэх зэргээр үйл ажиллагаа явуулж байна.

АНЭ-н бие даасан байдлыг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн чадавх дутмаг Салбарын хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг бодитой үнэлэх тогтолцоо бүрэн бүрэлдээгүй, хөндлөнгийн хяналтын механизм сул Эмч, эмнэлгийн мэргэжилтний харьцаа хандлага хангалтгүй Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, цогц арга хэмжээний хэрэгжилт, туүний хэрэгжилтийн үнэлгээ олон нийтэд ил тод бус байна.

Хоёр. ГАДААД ОРЧИН

Боломж

Эрсдэл

1. Аймгийн ИТХ, Засаг даргын тамгын газрын түвшинд

Улсын хэмжээнд Алсын хараа 2050, Аймгийн хэмжээнд таван жилийн хөгжлийн үндсэн чиглэл, Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг хөгжлийн бодлогыг тодорхойлсон бодлогын баримт бичиг батлагдан хэрэгжиж эхэлсэн. Мөн эрүүл мэндийн салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалтын дэмжлэг нэмэгдэж байгаа бөгөөд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлд суурилсан санхүүгийн шинэ тогтолцоогоор санхүүжилтээ авч байгаа зэрэг нь нэг талдаа боломж хэмээн харж байна.

Улс орны эдийн засгийн хямрал аймаг орон нутгийн төсвийн хязгаарлагдмал байдалтай холбоотойгоор бодлогын баримт бичигт тусгагдсан үйл ажиллагаа хэрэгжих боломжгүй болох, орон нутгийн эрүүл мэндийн салбарын санхүүжилт хөрөнгө оруулалтын хэмжээ буурах зэрэг эрсдэл гарч болох юм.

2. Хууль эрх зүйн зохицуулалтын хувьд

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай гэх мэт Хүн амын эрүүл мэндийг дэмжих хамгаалах

Эрүүл мэндийн салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа гол гол хуулиудад ойр ойрхон хугацаанд нэмэлт өөрчлөлт орж байгаа нь хуулийн хэрэгжилтэд сэргэөр

чиглэлээ хууль эрх зүйн орчин хангалттай бүрэлдсэн	нөлөөлж байна. Мөн хуулийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, дагаж мөрдөх журам байхгүй хэрэгжилтийг тогтмол хянах хүний нөөц, чадавх хангалттай бус байгаагаас хууль тогтоомжийн хэрэгжилт орон нутагт сул байна.
3. Аймаг орон нутгийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлт	
Жил ирэх тусам эдийн засаг тэлж байгаа болон уул уурхай, хилийн боомт шинээр нээгдэх зэрэг нь аймаг орон нутгийн бие даасан байдлаа хангах боломж бүрдэнэ.	Орон нутгийн засаглалын бодлого сул, бодлого тогтвортгүй иргэдийн хурлын төлөөлөгч нарын улс төржилт нь хөрөнгө оруулалтын орчныг муутгаж, шууд хөрөнгө

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх, эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор тусlamж үйлчилгээг орон нутагтаа чанартай хүргэх, хэнийг ч орхигдуулахгүй байх, үндсэн суурь зарчмыг бий болгох, эрүүл мэндийн байгууллагын чадавхийг бэхжүүлэн гүйцэтгэлийн санхүүжилт, цахим мэдээллийн тогтолцоог бүрэн нэвтрүүлж. эрүүл мэндийн тусlamжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийнэ.

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА ЗУРАГЛАЛ

2024 оны байдлаар завхан аймгийн хэмжээнд нийт 105 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба нийгмийн эрүүл мэндийн төв 1, Аймгийн нэгдсэн эмнэлэг 1, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 1, сумын эрүүл мэндийн төв 22, өрхийн эрүүл мэндийн төв 3, хувийн ортой эмнэлэг 1, ажиллаж аймгийн хэмжээнд эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг иргэдэд үзүүлж байна

НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ МАТРИЦ